



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2020 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 19,018,000 (арван есөн сая арван найман мянган) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Ц.Билэгтсайханд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг заасан хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг тулган баталгаажуулж тайлагнах;

2.3. Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2018-2019 онд хийгдсэн нийтийн эзэмшлийн байгууламжийн шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийг хангуулах, ашиглалтад хүлээн авч санхүүгийн тайланд тусгах;

2.4. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй, нийт 9,941,600 (есөн сая есөн зуун дөчин нэгэн мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэтэй, хувь хүний нэр дээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 12 айлын 3 үл хөдлөх (айлын орон сууц, цэцэрлэгийн байр) хөрөнгийн асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэх;

2.5. Төрийн өмчийн барилга байгууламжид 37 жил их засвар хийгдээгүйн улмаас үүссэн эрсдэлд мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэн өмчийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах;

2.6. Санхүүгийн тайлангийн үнэ болон бодит үнэ цэнийн хооронд мэдэгдэхүйц зөрүүтэй, цаашид ашиглах боломжтой хөдлөх хөрөнгийн ашиглах хугацаа, өртгийг шинэчлэн тогтоох;

2.7. Төрийн өмчийн барилгад суурилуулсан үүрэн телефоны компаниудын антены талбайг түрээслэх түрээсийн гурвалсан гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулж, орлогоос улсын төсөвт 40 хувийг төвлөрүүлж байх;

2.8.Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, дотоодын тооллогыг хангалтгүй зохион байгуулсан ажилтнуудад хариуцлага тооцох;

2.9.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 22 -ны өдрийн
24 дугаар тогтоолын хавсралт

Халдварт өвчин судлалын үндэсний төвд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /мянган төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Нийслэлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хийгдсэн шинэчлэлтийн ажлын дүнд ашиглалтгүй болж, буулгасан хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй	8,975.5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журам	Өргөтгөл шинэчлэлтийн ажилтай холбогдон ашиглалтгүй болж буулгах, устаж үгүй болох хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах асуудлыг тухай бүр шийдвэрлэж байх
2	Санхүүгийн тайлангийн үнэ болон бодит үнэ цэнийн хооронд мэдэгдэхүйц зөрүүтэй, ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацаа болон өртгийг шинэчлэн тогтоогоогүй	/211ширхэг/ 100.9	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйл.	Хөрөнгийн ашиглалтын хугацаа, өртгийг шинэчлэн тогтоох
3	Байгууллагын үндсэн хөрөнгөд, хувь хүний нэр дээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй	9,941.6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	Үл хөдлөх хөрөнгийн асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэх
4	Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт хадгалалт, хамгаалалт, дотоод хяналт хангалтгүй	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журам, стандарт	Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах
НИЙТ ДҮН:		19,018,000 (арван есөн сая арван найман мянган) мянган төгрөг		